



КРЕДИТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ББСБ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 11-ний өдөр

Дугаар 2021/08

Улаанбаатар хот

Ногдол ашиг тараах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 сарын 11-ний өдрийн эчнээ хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгийн дүнгээс 49.79% (дөчин ес зууны далан есөн хувь)-иар буюу 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 3.57 (гурав зууны тавин долоо) төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 сарын 9-ний өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар зуучлуулан гүйцэтгүүлж, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2021 оны 6 сарын 30-ны өдрийн дотор тараасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ